MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 17 өдөр Дугаар 164 Улаанбаатар хот

Арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, МХБ ТӨХК-ийн Дүрмийн 8.1, 8.10.11, МХБ ТӨХК-ийн "Хяналт шалгалтын журам"-ын 15.1.1, МХБ ТӨХК-ийн "Гишүүнчлэлийн журам"-ын 6.1.1, 6.1.4, "МХБ-ийн гишүүдийн ажилтны ёс зүйн дүрэм"-ийн 2.1, 2.5, 5.2, МХБ ТӨХК-иас гишүүн компанитай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний 2.4.1 дахь заалт, "Үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 7.3, 7.4 дахь заалт, Хяналтын албаны №01, 02 зөрчлийн хуудсыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. МХБ ТӨХК-ийн "Гишүүнчлэлийн журам", "Хамтран ажиллах гэрээ" болон бусад холбогдох гэрээний заалтуудыг зөрчсөн "Стандарт инвестмент" ҮЦК-ийн дилер Б.Эрдэнэжаргал, "Евразиа капитал холдинг" ҮЦК-ийн дилер М.Буянтогтох нар нь МХБ-ийн үнэт цаасны арилжааны Трейдэр программ хандах эрхийг бусдад дамжуулж, ажлын хариуцлага алдсан тул сануулах арга хэмжээ авсугай.

2. Цаашид үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Монгол улсын хууль тогтоомж, журам зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг "Стандарт инвестмент" ҮЦК-ийн захирал /Ч.Жаргал/, дилер /Б.Эрдэнэжаргал/, "Евразиа капитал холдинг" ҮЦК-ийн захирал /Г.Оюунболд/, дилер /М.Буянтогтох/ нарт хатуу анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.АНГАР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХХ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТТА2380.зх.20/1096
УЛААНБААТАР ХОТ